



## МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 03 сарын 24

Дугаар 01

Улаанбаатар хот

“Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Гомбын Аюушмаа даргалж, хувьцаа эзэмшигч Г.Аюушмаа /эзэмшдэг хувьцааны тоо-524/, Б.Зориг /768062/, Д.Тунгалаг /97792/, Н.Дуламжав /176/, Ц.Самданпунцаг /10/, А.Чулуун /5/, С.Ургамал /134/, Д.Оюун /1279/, “Стандарт инвестментс ҮЦК” ХХК /4/, түүнийг төлөөлж Н.Төгөлдөр /ГА86100211/, хурлын тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Лхагвачулуун нарыг оролцуулан “Материалимпэкс” ХК-ийн танхимд 2016 оны 03 сарын 24-ний өдрийн 10 цаг 30 минутад хийв.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, Аудитын хорооны гишүүн Д.Эрдэнэцэцэг, ТУЗ-ийн гишүүн Б.Зориг, Д.Тунгалаг, Д.Оюун, ТУЗ-ийн дарга Г.Аюушмаа нар оролцсон болно./

Даргалагчаас: Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа, компанийн ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд, хууль болон бусад холбогдох журамд заасны дагуу 2016.02.02-нд хувьцаа эзэмшигчдийн хурлын товоо гаргаж, хурлын тооллогын комиссыг томилсон байгаа. Миний бие Г.Аюушмаа ТУЗ-ийн даргын албан тушаалыг эрхэлдэг тул компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан эрхийн дагуу өнөөдрийн ХЭХ-ыг даргалан явуулах болно. Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулъя. Дарга П.Баатарцэрэн нягтлан бодогч мэргэжилтэй, гишүүн Л.Нямдулам мөн нягтлан бодогч мэргэжилтэй, Д.Баатардорж инженер мэргэжилтэй. Эдгээр хүмүүс өнөөдрийн хурлын тооллогын комиссоор томилогдсон байна. Комиссын дарга, гишүүд ирцээ бүртгэж, мэдээллээ танилцуулна.

Нарийн бичгийн дарга: /Тооллогын комиссын гишүүд хувьцаа эзэмшигч бүрийн итгэмжлэл, биеийн байцаалтыг шалгаж, тулгалт хийсэн ба Л.Нямдулам тэмдэглэл хөтөлснийг хавсаргав/. Ирцийн ажиллагаа хурал эхлэхээс 30 минутын өмнө эхэлсэн байна.

Тооллогын комиссын дарга П.Баатарцэрэнгээс: Ирцийн мэдээллийг танилцуулъя. 2016.03.24-ний өдрийн 10 цаг 30 минутын байдлаар 1,368,206 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс 867986 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид ирсэн байна, ирц 63,5% байна гэв.

Даргалагчаас: Саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцох хууль зүйн үндэстэй байна. Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

- Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэх, батлах
- Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, батлах

- Компанийн хөндлөнгийн Аудитын байгууллагыг томилох, түүнтэй гэрээ байгуулах этгээдийг томилох
- Ногдол ашиг хуваарилсан талаархи мэдээлэл сонсох зэрэг асуудлуудыг хэлэлцэх болно.

Хурлын дараалал, дотоод журам /тэмдэглэлд хавсаргав/-ыг танилцуулаад Хэлэлцэх асуудлын дараалал болон бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдэд асуух болон хэлэх санал хүсэлт байна уу? Хурлын материалыг Монголын Хөрөнгийн Бирж болон өөрийн сайтдаа байршуулсан, үнэт цаасны компаниуд руу мэйлээр явуулсан зэрэг энэ жил цаасаар биш цахимаар хурлаа хийх бодлого баримталж байгаа. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлаас өмнө шаардлагатай материалтайгаа ирж танилцах бүрэн боломж үргэлж нээлттэй байдаг. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцэх асуудал тус бүрт чөлөөтэй, идэвхитэй асууж, хариулж, сонирхсон бусад зүйлсээ минут харгалзахгүйгээр чөлөөтэй асууж болно.

Оролцогчид: Дараалал, хурлын материалтай танилцсан тул хэлэлцэх асуудалд оруулах саналгүй, асуулт хариултын журмаар явуулахыг дэмжиж байна гэцгээв.

Даргалагчаас: Хурлын зарыг СЗХ-оос батлагдсан журмын дагуу явуулсан гэдгээ дурдъя. За ингээд асуух зүйл байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё. 2015 оны тайлант хугацааны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлт дэлгэц дээр гарсан байна. Дахин уншиж танилцана уу.

/10 цаг 43 минут хүртэл үргэлжлэв/

Даргалагчаас: Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтээс асууж тодруулах, нэмж хасах санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Асуултаа хэдийд ч тавьж болно шүү. Дараагийн хэлэлцэх асуудал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт дэлгэц дээр гарч ирсэн байна. Уншиж танилцаад асуулт хариултдаа оръё.

/10 цаг 46 минут хүртэл үргэлжлэв/

Н.Дуламжаваас: Өмнөх жилээс ашиг буурсан шалтгаан нь юу вэ?

Д.Эрдэнэцэцэгээс: Улс нийтээрээ эдийн засгийн хямралтай байгааг хэн бүхэн мэдэж байгаа. Үүнтэй холбоотойгоор борлуулалт буурсан гэх мэтчилэн олон хүчин зүйлс нөлөөлсөн гэв.

Н.Дуламжаваас: Тээвэр зуучийн үйл ажиллагаа хэр байна вэ?

Д.Эрдэнэцэцэгээс: Буурсан дүнтэй байгаа гэв.

Н.Дуламжаваас: Монгол шуудан компани манай компанитай өрсөлдөгч компани уу?

Б.Зоригоос: Үйл ажиллагааны чиглэл өөр учраас өрсөлдөгч биш гэв.

Н.Дуламжаваас: Энэ жил манай хувьцааны үнэ багагүй унасан байгаа. Шалтгаан нь юу гэж бодож байна вэ?

Б.Зоригоос: Мөн л хямралтай холбоотойгоор бүх орлого төлөвлөснөөс багасаж, ашиг 3 дахин буурсан нь хувьцааны үнэ ханш буурахад нөлөөлсөн байх гэв.

Н.Дуламжаваас: Аялал жуулчлалын салбар маань хэр байна вэ?

Б.Зоригоос: Урд онтой харьцуулахад мөн л багассан гэв.

Ц.Самданпунцагаас: Хувьцааны үнэ дахиад өсөх үү?

Б.Зоригоос: Тэрийг хэлж мэдэхгүй, мэдээж үйл ажиллагаа сайжирвал дагаад л өсөх байлгүй дээ. Дандаа ийм байхгүй байх аа гэв.

Н.Дуламжаваас: Санал хэлэх гэсэн юм гэв.

Даргалагчаас: Болно болно гэв.

Н.Дуламжаваас: АПУ, СҮҮ ХК-иуд хувьцаагаа хувааж байна л даа. Миний мэдэхээр АПУ 3 дахь удаагаа хувааж байгаа, одоо 10 дахин хувааж байна. Хувьцааг хуваах нь бид мэтийн жижиг хувьцаа эзэмшигчдэд үр өгөөжтэй байдаг. Энэ талаар хуваах бодол бий юу? Үнэлгээ талаасаа 15 мянгаас 7 мянга хүртэл буурсан байна, хэрэв хувьцаагаа хуваавал компанийн үнэлгээ ч өснө гэж бодож байна. ноднингийхоосоо ашиг багассан ч манайх хасах заадаггүй, үйл ажиллагаа сайтай шүү дээ, тийм болохоор хувьцаа хуваах талаар бодвол зүгээр юм шиг санагдаж байна. яваандаа буцаад 14-15 мянгадаа нэгж хувьцаа хүрэх л байх гэв.

Б.Зоригоос: Яг одоохондоо ийм тийм санаа оноо алга байна, анх удаа хувьцаа хуваах талаар хувьцаа эзэмшигчээс санал гаргаж байгаа болохоор энэ талаар ТУЗ-өөсөө судлаад үзье.

Н.Дуламжаваас: Миний ойлгосноор бол ашигтай ажиллаж байгаа газрууд хувьцаагаа хуваадаг юм байна лээ, харин хөрөнгө босгох гэж байгаа газар бол хувьцаа нэмж гаргадаг юм шиг байгаа юм. Ийм санал байгааг харж үзээрэй гэв.

Даргалагчаас: За хөрөнгө оруулагчийнхаа саналыг ТУЗ-дөө танилцуулж судалж үзнэ ээ гэв.

Н.Дуламжаваас: Манайд бол нэмж хувьцаа гаргах хэрэггүй гэж боддог гэв.

Н.Төгөлдөрөөс: Зээл авах гэж байгаа бол нэмж хувьцаа гаргасан нь дээр байдаг гэв.

Даргалагчаас: Банкнаас мөнгө зээлж байснаас хөрөнгийн зах зээлээс хөрөнгө төвлөрүүлэх нь ашигтай л даа.

Н.Дуламжаваас: За ийм саналтай байна гэв.

Ц.Самданпунцагаас: Хувьцаа хуваах их ашигтай шүү гэв.

Б.Зоригоос: Хувьцаа нэмж гаргах талаар санал бол гарч байсан боловч бидэнд тэгж хөрөнгө төвлөрүүлэх онцын их шаардлага байхгүй гэж үзээд нэмж гаргаагүй. Гэхдээ юмыг яаж мэдэхэв хэзээ нэгэн цагт хэрэгжих ч юм билүү гээд бид ноднин Дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа энэ талаар тусгасныг санаж байгаа байх гэв.

Даргалагчаас: Хэлэлцэж байгаа асуудлаас өөр асууж тодруулах зүйл, нэмж хэлэх санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Дараачийн хэлэлцэх асуудал 2016 оны бизнес төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Б.Зоригоос хэлэлцүүлнэ. Дэлгэц дээр дэлгэрэнгүйгээр гарч байна, үүнээс асуух зүйлээ тухай бүрт нь тодруулаад яваарай.

Н.Дуламжаваас: Бид өмнө нь бол ер нь бүгдтэй танилцсан шүү дээ. Тэгэхээр ингэж нэг нэг хуудсаар нь гаргаж цаг алдах хэрэг байна уу? Яг шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэл ч юм уу, тодорхой шинэ юмаа л ярьж тэгэх үү?

Бусад оролцогчид: Саналыг дэмжиж байна, гол зүйлсээ л сонсьё гэв.

Б.Зоригоос: 2016 онд хямрал үргэлжлэх байх гэж бодсон учраас ямар ч байсан 2015 оны гүйцэтгэлээ бууруулахгүй, бага ч боловч ахиулж, зардлаа хэмнэх зорит тавьсан. Шинээр ямар нэгэн томоохон хэмжээний төсөл ч юм уу, хөрөнгө оруулалт хийхгүй, хэрэгжүүлж байгаа төслөө үргэлжлүүлэх бодлоготой ажиллана. Ер нь бол цэвэр ашгаа нэмэгдүүлж 1,3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллана гэж төлөвлөж байна гэв.

Н.Дуламжаваас: Ашгийг яг аль салбар нэгжээс нэмэгдүүлнэ гэж тооцоолов?

Б.Зоригоос: Зардлаа хэмнэнэ, задаргаа бол маш олон зүйлээс бага бага хэмжээгээр хэмнэлт хийнэ, гол нь өртөгөө бууруулна гэв.

Н.Дуламжаваас: Орон тооны цомхотгол хийх юм уу?

Б.Зоригоос: Үгүй, цомхотгол биш, ямар нэгэн урамшуулал олгохгүйгээр хэмнэлтээ тооцоолсон гэв.

Н.Дуламжаваас: Гол нь үйл ажиллагаагаа сайжруулах гэж байгаа юм уу, жишээ нь арматураа хэрхэн яаж борлуулах вэ ч гэдэг юм уу? Шинэ юм байна уу?

Б.Зоригоос: Яг шинэ юм төлөвлөөгүй, үйл ажиллагаагаа сайжруулах төлөвлөгөөтэй гэв.

Н.Төгөлдөрөөс: Зээлийн хүүгийн зардал гэж юу вэ?

Б.Зоригоос: Банкны баталгааны шимтгэл гэв.

Н.Төгөлдөрөөс: Одоо банкинд зээлтэй байгаа юу?

Б.Зоригоос: Банкнд зээл байгаа, гэхдээ хугацаа хэтэрсэн, нэмэгдүүлсэн хүү тооцуулсан зээл байхгүй. Ер нь энэ төлөвлөгөө бол маш бодит тоон үзүүлэлтэнд тулгуурлан хийсэн гэв.

Даргалагчаас: Ам доллар, валютын ханш өсөөд байвал төлөвлөгөө бас биелэх эсэх эргэлзээтэй болно.

А.Чулуунаас: Өнгөрсөн онд компани бага биш ашигтай ажиллажээ. Энэ ашгаа юунд зарцуулах вэ?

Б.Зоригоос: Манай компани жил бүрийнхээ ашгийг ирэх жилийнхээ үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөгжүүлэхэд дэмжиж ажилладаг. Ер нь бол ашгаа бүгдийг ногдол ашиг болгон тараах бодлого баримталдаггүй. Үйлдвэрлэлүүдийн ашигтай ажиллагааг дэмжиж ашгаа ашиглана гэв.

Ц.Самданпунцагаас: Цементийг дотоодоосоо худалдан авдаг уу?

Б.Зоригоос: Гаднаас ч авна, дотоодоосоо ч авдаг гэв.

Н.Дуламжаваас: Арматурын хувьд дотоодын Хөх Ган гээд бас хийх гээд байх шиг байна?

Б.Зоригоос: Ер нь бол дотоодын арматурын үйлдвэрүүдээс Дарханы арматурын үйлдвэртэй нэлээд хамтарч ажилладаг байсан. Гэхдээ хүрэлцээ нь их бага байдаг, Багахангай гэх мэтийн газруудын арматурууд чанарын хувьд шаардлага хангаж чаддаггүй тал бий, тэдгээр нь дан юм уу 2 давхар ч юм уу намхан барилгын хувьд болох л байх. Гэтэл манай худалдан авагчид зөвхөн олон улсын стандартад нийцсэн арматур авахыг хүсдэг. Бид гэхдээ хятадаас арматур оруулж ирэхдээ хувийн ч юм уу жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн авдаггүй гэв.

Ц.Самданпунцагаас: Бугат бол их том үйлдвэр байна билээ гэв.

Б.Зоригоос: Том оо том, дэлхийн 500 том үйлдвэрийн нэгд ордог гэв.

Даргалагчаас: Төлөвлөгөөнөөс өөр асуух асуулт, хэлэх санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Одоо Ногдол ашгийн хуваарилалтын талаар мэдээлье.

2015 онд компани бага ч гэсэн хэмжээний ашигтай ажилласан юм чинь хөрөнгө оруулагчиддаа бага ч гэсэн хэмжээний ногдол ашиг өгсөн нь зөв гэж ТУЗ дүгнээд нэгж хувьцаанд 30 төгрөгөөр тооцож ногдол ашиг хуваарилаар шийдвэрлэсэн байгааг хувьцаа эзэмшигчиддээ мэдээлж байна. ногдол ашиг хуваарилсантай холбоотойгоор асуух асуулт байна уу?

Ц.Самданпунцагаас: Ногдол ашгийн мөнгийг хаанаас өгдөг юм бэ?

Нарийн бичгийн даргаас: ҮЦТТХТ ХХК-иар авна гэв.

Даргалагчаас: Ногдол ашигтай холбоотой нэмж асуух асуулт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх сүүлчийн асуудал бол хөндлөнгийн аудит хийх байгууллагын тухай юм. Ноднингийн ХЭХ-аар баталсан “Мишээл ОД Аудит” ХХК нь СЗХ-ноос олгодог тусгай зөвшөөрөлтэй байгууллага биш байсан учраас бид мэдсэн даруйдаа ТУЗ-өөрөө хуралдаж, Хорооноос зохих чиглэлээ авч эрх бүхий байгууллагаар нь сольж шийдвэрлэсэн. Ингээд 2014 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд “Координат аудит” ХХК-иар дүгнэлт хийлгэсэн байгаа. Энэ

компаниар энэ жил болон ирэх 4 жил хийлгэх саналыг ХЭХ-даа танилцуулж байна. энэ талаар саналаа хэлцгээнэ үү.

Оролцогчид: Татгалзах зүйлгүй, асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор нэмж гаргах санал, хүсэлт, асуулт байна уу?

Н.Дуламжаваас: Би саналаа түрүүн хэлчихсэн учраас давтаад яах вэ. Энэ жилийн бизнес төлөвлөгөөг их бодитой болжээ гэж бодож байна гэв.

Бусад оролцогчид: Асуух асуултгүй, нэмж хэлэх санал байхгүй байна гэв.

Даргалагчаас: Тооллогын комисс саналын хуудсаа тараая.

/Тооллогын комиссын гишүүд санал авах хуудас тарааж бөглөх журмыг тайлбарлан өгөв.

Тооллогын комиссын гишүүд санал авах хуудсыг хураан авч саналын хуудсаа тоолов/

Тооллогын комиссын дарга П.Баатарцэрэнгээс: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Тооллогын комиссын саналын хайрцагийг нээж шалгахад 9 хуудас гарснаас 9 хуудсыг хүчинтэйд тооцож,
2. Хүчинтэйд тооцогдсон саналын хуудсаар дүгнэхэд хэлэлцүүлж буй асуудлыг доорхи хувиар зөвшөөрснийг тогтоов. Үүнд :

- ❖ Компанийн 2015 үйл ажиллагааны болон санхүүгийн *байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг* зөвшөөрсөн 100 хувь
- ❖ *Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрсөн*
- ❖ Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрсөн 100 хувь
- ❖ Компанийн хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, түүнтэй гэрээ байгуулах этээдийг томилохыг зөвшөөрсөн 100 хувь гэснийг уншиж танилцуулав.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг сонслоо. Ингээд ХЭХ-аас тогтоол гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг тус тус Хавсралт №01-ээр, Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №02-оор тус тус баталж,
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал шүүмжлэл, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02 утга:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол улсын “Координат Аудит” ХХК-ийг томилж,
2. “Координат Аудит” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгоэ,
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгоод

Тогтоол тус бүрт Хурлын дарга гарын үсэг зурсан тухай уншиж танилцуулав.

Ингээд хуралдаа ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 11 цаг 40 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

ХУРЛЫН ДАРГА

Г.АЮУШМАА